



ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 04 сарын 25 өдөр

Дугаар А/226

Эрдэнэт

Их наадмын арга хэмжээнд
хөрөнгө гаргах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 /а/, 29.2, Соёлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 /1,2/ дахь заалт, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн ээлжит 4 дүгээр хуралдааны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орхон аймагт 04 дүгээр сарын 29-ний өдөр болох “Бүжин наадъя” их наадмын арга хэмжээнд 3500000 / Гурван сая таван зуун мянган/ төгрөгийн дэмжлэгийг үзүүлсүгэй.

2. Шаардагдах зардал 3500000 / Гурван сая таван зуун мянган/ төгрөгийг Засаг даргын нөөц сан хуваарилагдаагүй бусад зардлын жагсаалтын “Улсын чанартай спорт, соёл урлагийн арга хэмжээг жилд 2-оос доошгүй төрлөөр орон нутагтаа зохион байгуулах” арга хэмжээний зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д. БАТЛУТ



D:(Zahiramj) A-4 doc

0000021098